



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024. 11. 24 № ТБ-134-12/4486
танай _____-ны № _____-т

Тодруулгад хариу өгөх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/202401011344 дугаартай “Хүдэр бэлтгэх нэгдүгээр шатны бутлуурын шинэчлэлийн ажил” тендерийн 2 дугаар багц “Хүдэр бэлтгэх нэгдүгээр шатны бутлуурын шинэчлэлийн ажлын барилга угсралтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг сонирхогчоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407037945

ТОДРУУЛГЫН ХАРИУ

Тодруулга №1: Тендерийн шаардлагад дурдсан төмөр бетон суурийн газар шорооны ажилд ашиглагдах бульдозер / 90 морины хүчтэй / болон экскаваторын / 0,65 м3 / хүчин чадлын маш багаар тооцон тусгасан нь төсөвт өртгийн механизмын зардал алдагдалтай байхаар байна.

Хариулт: Ашиглах боломжтой механизмын зардлаар тооцож үнийн санал явуулж болно.

Тодруулга №2: Барилгын ерөнхий зохион байгуулалтын зураг төсөл байхгүй. Энэхүү зургийг зураг төслийн ерөнхий гүйцэтгэгч эсвэл түүний даалгавраар зургийн өөр компани боловсруулан гүйцэтгэдэг.

Хариулт: Гүйцэтгэгч байгууллага барилгын талбайн зохион байгуулалтын зургийн боловсруулна.

Тодруулга №3: Суурийн ухмалаас гарсан шороог зөөж тээвэрлэх зай болон асгах газар тусгагдаагүй.

Хариулт: Тендерт оролцогч байгууллага суурийн ухмалаас гарсан шороог зөөж тээвэрлэх зай болон асгах газрыг журмын дагуу сонгож тооцно.

Тодруулга №4: Хамгаалалтын даланд ашиглах шороо / 21700 м3 /, замын хөвөөнд ашиглах дайргыг / 5000-10000 м3 / зөөж тээвэрлэх зай мөн тусгагдаагүй.

Хариулт: Тендерт оролцогч байгууллага суурийн ухмалаас гарсан шороог зөөж тээвэрлэх зай болон асгах газрыг журмын дагуу сонгож тооцно.

Тодруулга №5: Тендерийн ажлын тоо хэмжээнд:

- Бетоны нягтын коэффициент
- Хаягдал арматурын коэффициент
- Профлист угсрах үед босоо болон хэвтээ ирмэгийн зөрүүлэг ямар байх
- Хана болон дээврийн сэндвич хавтан угсрахад босоо болон хэвтээ ирмэгийн зөрүүлэг ямар байх зэргийн зааггүй

Хариулт: Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын төсөв зохиох норм ба дүрмийн дагуу тооцно.

Тодруулга №6: Бүх объектын төмөр хийцийн болон техникийн шаардлага байхгүй

Хариулт: Барилгын норм ба дүрмийн дагуу ган хийцийг шаардана.

Тодруулга №7: Зарим объектын зураг төсөл дээрх ажлын тоо хэмжээ нь тендерийн тоо хэмжээнээс их байна

Хариулт: Зураг төслийн дагуу тоо хэмжээг шаардана.

Тодруулга №8: Бетонд суулгах жижиг төмөр хэсгүүдийн бэхэлгээний цэгүүдийг заагаагүй, галерей төмөр бетон хана, таазаар угсрах шугам хоолойн бетонд суулгах жижиг төмөр хэсгүүдийн тоо ширхэг байхгүй

Хариулт: Бетонд суулгах жижиг төмөр хэсгүүдийн байршлыг тоног төхөөрөмж нийлүүлэлттэй уялдуулан ажил гүйцэтгэх үед дахин тодруулна.

Тодруулга №9: БУА-н тоо хэмжээнд барилгын шат угсрах болон буулгах ажил тусгагдаагүй.

Хариулт: Тендерт оролцогч байгууллага БУА-н тоо хэмжээнд барилгын шат угсрах болон буулгах ажлыг тооцож оруулна.